



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,  
Бага гойруу, 13/1, Утас: 26-63-09, Факс: 32-99-33  
E-mail: info@cd.gov.mn, http://www.cd.gov.mn/


2017.04.08 № 27/1239

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХАРЬЯА ГАЗАР, ХОРИХ АНГИ, ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ АЛБА, САЛБАР, НЭГЖИЙН  
ДАРГА НАРТ**

ШШГЕГ-ын даргын 2017 оны А/72 дугаар тушаалын хавсралтаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын буудлага үйлдэх байгууламжийг ашиглах хяналт тавих журам", "Буудлагын зэвсгээр буудлага үйлдэх үеийн аюулгүйн арга хэмжээний заавар", "Сум галт хэрэглэлийн зарцуулалт, үйлчилгээнд хөтлөгдөх бүртгэлийн хүснэгт"-ийг баталсан тул үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг мэдэгдье.

ДЭД ДАРГА  
ХУРАНДАА  Ж. БАТСАЙХАН





ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар

А/92

Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай

“Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Галт зэвсгийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.7 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын буудлага үйлдэх байгууламжийг ашиглах, хяналт тавих журам”-ыг нэгдүгээр, “Буудлагын зэвсгээр буудлага үйлдэх үеийн аюулгүйн арга хэмжээний заавар”-ыг хоёрдугаар, “Сум, галт хэрэглэлийн зарцуулалт, үйлчилгээнд хөтлөгдөх бүртгэлийн хүснэгт”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Журам, зааврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг харьяа газар, хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Журам, зааврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тусгай ажиллагааны газарт даалгасугай.

4. Холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Санхүү, хангамжийн газар /хошууч Я.Ган-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй.

5. Энэ тушаалыг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Ц.АМГАЛАНБАЯР

0003564

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн 1 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт /32

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН БУУДЛАГА ҮЙЛДЭХ БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын буудлага үйлдэх байгууламж /цаашид тир гэх/-ийг ашиглах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын "Галт зэвсгийн тухай" хууль, Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын галт зэвсэг, хэрэглэлийг бүртгэх, олгох, хадгалах, хяналт тавих журам" болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Тир нь галт зэвсэг түүнтэй адилтгах хэрэгслээр дадлага, сургалт явуулах, шалгах, турших, засварлах зориулалт бүхий байгууламж байна.

### Хоёр. Буудлага үйлдэх байгууламжийн зориулалт

2.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад буудлагын зэвсгийн бүтэц, тактик техникийн өгөгдөхүүн, гал явуулах дэглэм, аюулгүй ажиллагааны журам, зааврыг танилцуулж, буудлага үйлдэх, дадлага хийлгэх, галт зэвсэг эзэмших, ашиглах ур чадварыг нэмэгдүүлэх;

2.2. Шийдвэр гүйцэтгэгч нарт галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл эзэмших, ашиглах чадвар олгох, буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагааг хангах;

2.3. Галт зэвсгээр буудлага үйлдэх аюулгүй ажиллагааны журам, зааврыг сахиулж, нормативуудыг хангуулах;

2.4. Буудлагын тирэнд хууль, журамд зааснаар хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн галт зэвсэгтэй харьцах, аюулгүй хэрэглэх, мэргэн буудах сургалт зохион байгуулах, буу тусгалд оруулах, засварлах, дуран тохируулах зэрэг төлбөртэй үйлчилгээ үзүүлж болно.

2.5. Тусгай ажиллагааны газар нь буудлагын тирний үйл ажиллагааг хариуцан ажиллуулна.

### Гурав. Тавигдах шаардлага

3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын буудлагын тир нь Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 433, А/248 дугаар тушаалаар батлагдсан "Буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага"-д нийцсэн байна.

3.2. Буудлагын тир нь стандарт шаардлагад нийцсэн галт зэвсгийн ажиллагааг шалгахад зориулсан зай, талбай, тоног төхөөрөмж, зориулалтын суурь, тавиуртай байх ба аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий зааварлагчтай байна.

3.3. Буудлагын хагас битүү болон задгай тир нь сумны нисэх зайг тооцоолон аюулгүйн бүсийг барьж, хүн, мал, амьтан нэвтрэхгүй хашаагаар тусгаарлан телекамер болон хамгаалалтын хэрэгслээр тоноглогдоно.

3.4. Буудлага үйлдэх үед телекамерийн бичлэг хийгдэнэ.

3.5. Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, галын болон бусад дохиоллын системээр тоноглогдсон байна.

3.6.Аваар ослын үед гарах гарц, шат хаалганы схем байрлуулсан байна.

### **Дөрөв. Аюулгүй ажиллагаа**

4.1.Буудлагын удирдагч нь буудлага үйлдэгчийг сонор сэрэмжтэй, сахилга зохион байгуулалттай оролцох, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлах, гарц болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн авна.

4.2.Буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагааны санамж, буудлагын чиглэл, гарцыг тэмдэглэсэн схем, зурагт хуудас, самбар байрлуулсан байна.

4.3.Буудлага эхлэхийн өмнө тирэнд үзлэг хийж, буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.4.Буудлага явагдах үед хаалганд “Нэвтрэхийг хориглоно”, “Анхаар буудлага үйлдэж байна” гэсэн сэрэмжлүүлэх бичиг байрлуулна.

4.5.Тэсрээгүй сум, хэрэгслийг илрүүлсний дараа анхааруулах бичигтэй заагчаар тэмдэглэн үлдээж буудлагын удирдагчид мэдэгдэнэ.

### **Тав. Хүлээх үүрэг**

5.1.Тирийг Тусгай ажиллагааны газрын Мэргэжлийн удирдлагын тасгийн дарга, тусгай ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн нар хариуцан ажиллуулж, дараах үүргийг хүлээнэ.

5.1.1.Тусгай ажиллагааны газраас баталсан хуваарийн дагуу анги, нэгжүүдэд буудлагын сургалт, хичээл, дадлага зохион байгуулах;

5.1.2.Буудлагын тирэнд тавигдах шаардлага, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.3.Зэвсгийг эвдэж гэмтээсэн, ажиллагаагүй болгосон, алдаж үрэгдүүлсэн, аюулгүй ажиллагааны журам, заавар зөрчсөн этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэж, хохирлыг нөхөн төлүүлэх;

5.1.4.Гэрээний дагуу буудлага үйлдэж буй буудлага үйлдэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5.1.5.Буудлагын тирд шинээр ирсэн сургалтын зориулалттай зэвсэг, тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар алба хаагчдад танилцуулж, сургалт зохион байгуулахаас өмнө хүн бүрт зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах;

5.2.Буудлагын удирдагч нь дараах үүргийг хүлээнэ.

5.2.1.Галт зэвсэг, тирний нөхцөл байдал, гэрэлтүүлэг болон бусад хэрэгслийн бүрэн бүтэн эсэхийг урьдчилан шалгаж энэ тухай тэмдэглэл үйлдэх;

5.2.2.Буудлага дууссаны дараа тир болон галт зэвсгийг шалгаж, цэвэрлэгээ, үйлчилгээг хийлгэх;

5.2.3.Буудлагын аюулгүй байдлыг хангаж, зөрчил илэрвэл энэ тухай тэмдэглэл үйлдэж, нэн даруй нэгжийн даргад илтгэх;

5.2.4.Буудлага үйлдэгчийн биеийн эрүүл мэндэд өөрчлөлт орсон, гэмтэж бэртсэн тохиолдолдгалыг зогсоож, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээгнэн даруй үзүүлнэ.

5.3.Дадлагажигч нь дараах үүргийг хүлээнэ.

5.3.1.Галт зэвсэг хадгалах, хэрэглэх, эзэмших, ашиглах онолын болон практик дадлага, чадварт идэвхийлэн суралцах;

5.3.2.Буудлагын аюулгүй ажиллагааны заавартай танилцаж сайтар судлах,

5.3.3.Буудлага үйлдэх командыг сайн сонсож, алдаагүй гүйцэтгэх;

5.3.4.Буудлагын явцад алдаа гарвал галт зэвсгийг аюулгүй болгож, гал хамгаалагчийг түгжсэний дараа буудлагын удирдагчид илтгэх;

5.3.5.Байгууламжийн эд хогшил, галт зэвсэг, бусад хэрэгсэлд хайр гамтай хандах;

5.4.Гэрээний дагуу буудлага үйлдэж буй хувь хүн, хуулийн этгээд нь энэ журамболон аюулгүйн арга хэмжээний зааврыг мөрдөж, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.

#### **Зургаа. Ашиглах, хяналт тавих**

6.1.Буудлагын тир ажиллуулах цагийн хуваарийг Тусгай ажиллагааны газрын дарга батална.

6.2.Тир ажиллуулах нэгж нь буудлагын тирний ашиглалтад хяналт тавьж, тирэнд нэвтрэх болон буудлага үйлдэх зөвшөөрөл олгоно.

6.3.Буудлага үйлдэх, буудлага хийх гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээд нь буудлага үйлдэх хүний тоо, галт зэвсэг, хэрэглэлийн төрлийг заасан зөвшөөрлийг албан бичгээр авна.

6.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжүүд буудлагын тирэнд өөрсдийн галт зэвсгээр буудлага үйлдэхийг зөвшөөрнө.

6.5.Буудлага үйлдэгч нь галт зэвсгийн бүтэц, техникийн өгөгдөхүүнийг судалж, онолын мэдлэг эзэмшсэн, аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцаж, гарын үсэг зурсан байна.

#### **Долоо. Хориглох зүйл**

7.1.Зөвшөөрөлгүй буудлагын тирэнд нэвтрэх;

7.2.Буудлагын тирэнд согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах;

7.3.Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн этгээдийг нэвтрүүлэх;

7.4.Буудлага үйлдэгчийн анхаарлыг сарниулах;

7.5.Буудлагын удирдагчийн зөвшөөрөлгүй галт зэвсэг, хэрэглэл авах, буудлага үйлдэх;

7.6.Гал нээх зааг дээр бугаа гараас салгах, эзэнгүй орхих, бусдад шилжүүлэх;

7.7.Буудлагын удирдагчаас "ГАЛЛА" команд, дохио өгөх, "ГАЛ НЭЭХ" заагт гарахаас өмнө буга сумлах;

7.8.Гал нээх зааг дээр бууны замгийг шалгахгүй, түгжилгүйгээр орхих;

7.9.Гал нээх зааг дээр буудлага үйлдээгүй байгаа хүмүүсийг ойртуулах;

7.10.Буга сумласан, сумлаагүй аль ч тохиолдолд хүн, хажуу тийш болон буудлагын талбайн ар тал руу чиглүүлэх;

7.11.Байны шугамын гэрлийг асааж унтраах;

7.12.Гэмтэлтэй зэвсгээр гал явуулах;

7.13.Аюултай чиглэлд болон удирдлагын байр дээр цагаан дарцаг босгосон үед гал нээх;

7.14.Тэсрээгүй үлдсэн сум ба бусад тэсрэх аюултай зүйл байгаа буудлагын талбайн хэсэгт нэвтрэх;

7.15.Тэсрээгүй сум болон бусад тэсрэх аюултай зүйлийг оролдох;

7.16.Байгууламжийг зориулалтын бусаар ашиглах, сум галт хэрэгслийг удаан хугацаанд хадгалах;

7.17.Аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцаж, гарын үсэг зураагүй хүнийг буудлагын тирэнд нэвтрүүлэх;

7.18.Буудлагын тирэнд гар утастай нэвтрэх;

7.19.Галт зэвсэг гацсан, сум баарсан зэрэг техникийн ямар нэгэн саатал гарсан үед галт зэвсгийг дур мэдэн задлах, оролдох;

7.20.Хэрэглэгдээгүй болон тэсрээгүй сум хэрэгслийг зөвшөөрөлгүй буудлагын тирнээс гадагш авч гарах;

7.21.Хайрцагтай галт хэрэгслийг чирэх, унагах, шидэх;

7.22.Галт хэрэглэлтэй хайрцагт ямар нэгэн зүйлийг хадаж бэхлэх;

7.23. Галт зэвсэг, сумыг тус тусад нь хадгалах ба тэсрэх хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дуу, гэрэл гаргах зориулалт бүхий галт хэрэгслийн хамт хадгалах.


### Найм. Бусад

8.1. Энэ журмыг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага оногдуулна.

8.2. Буудлагын тирийг ашиглахтай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас дэмжлэг туслалцаа авч, хамтран ажиллаж болно.

---oOo---

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн 1 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## БУУДЛАГЫН ЗЭВСГЭЭР БУУДЛАГА ХИЙХ ҮЕИЙН АЮУЛГҮЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Буудлагын үеийн аюулгүй байдал нь буудлагын зохион байгуулалт, аюулгүй арга хэмжээний шаардлагыг биелүүлэх, буудлага үйлдэгчид буудлагын сахилга батыг нэг бүрчлэн сахиснаар хангагдана.

1.2. Аюулгүй арга хэмжээ нь зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээнүүдээс бүрдэнэ.

1.2.1. Зохион байгуулалтын арга хэмжээнд буудлагын бэлтгэл хичээлийг явуулах, зааварчилгаа өгөх, буудлага үйлдэх эрх олгох, бичиг баримтуудыг бүрдүүлэх, буудлагын талбай, тирийг төхөөрөмжилж бэлэн болгох, бай, хичээлийн байрны аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн хангалтыг зохион байгуулах, харуул хамгаалалтыг гаргах, бусад арга хэмжээ.

1.2.2. Техникийн арга хэмжээнд хамгаалах хэрэгсэл ашиглах, зэвсэглэл, буудлагын талбай ба тирэнд цаг тухайд нь үзлэг, үйлчилгээ хийх, галт хэрэглэлд үзлэг хийж ашиглалтад тэнцэхгүй галт хэрэглэлийг хасах, буудлагын үед зэвсэглэлтэй аюулгүй харьцах арга барилд сурах, бусад арга хэмжээ.

1.3. Аюулгүйн арга хэмжээг судалж мэдээгүй бие бүрэлдэхүүнээр буудлага хийлгэхийг хатуу хориглоно.

1.4. Буудлага зохион байгуулах нэгжийн дарга нь тогтоосон аюулгүйн арга хэмжээг нийт бие бүрэлдэхүүнээр мөрдүүлнэ.

1.5. Буудлагын өмнө харуул, хянагчийг томилж, үзлэг хийлгэж, буудлагын талбайгаас хүн, мал, тээврийн хэрэгслийг гаргасан байна.

### Хоёр. Буудлагыг зохион байгуулах үед авах арга хэмжээ

2.1. Буудлагыг зохион байгуулах үед дараах арга хэмжээг авна. Үүнд:

2.1.1. Буудлагын хичээлийг зориулалтын, тусгай буудлагын талбай, тирэнд явуулна.

2.1.2. Буудлагын удирдагч нь буудлага хийлгэх зохих мэдлэг дадлагатай, галын бэлтгэл хичээлийг явуулах тодорхой арга барил эзэмшсэн байна.

2.1.3. Буудлагын өмнө галт зэвсгийн эд анги, буудах арга барил, дүрмийг судлуулж аюулгүйн заавар өгсөн байна.

2.1.4. Зэвсэг бүрэн бүтэн, цэвэрлэгдсэн /гол төмөр хуурай болтол арчигдсан/, галт хэрэглэл хонхойлт, эвдрэл гэмтэлгүй, зэврэлтгүй байх. Гэмтэлтэй зэвсгээр буудлага хийхийг хатуу хориглоно.

2.1.5. Буудлага үйлдэх бие бүрэлдэхүүнд зааварчилгаа өгч, зэвсэгтэй харьцах үед баримтлах аюулгүйн арга хэмжээг танилцуулж, бүртгэл хөтлөн гарын үсэг зуруулсан байна.

2.1.6. Ойрын зайд буудлага хийх дасгал боловсруулах үед байнаас сум эргэж ойхгүй байх арга хэмжээг авна.

### Гурав. Буудлага хийх үед авах арга хэмжээ

3.1. Буудлага хийх үед дараах аюулгүйн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Буудлагын удирдагч нь аюулгүйн арга хэмжээг дагаж мөрдөхийг буудлагад оролцогч бие бүрэлдэхүүнээс шаардаж, биелэлтэд хяналт тавих;
- Буудлагын удирдагчийн дохиогоор бүх үйл ажиллагааг явуулна. Зөвхөн галын шугам дээр буудлагын удирдагч /хичээлийн удирдагч/-ийн дохиогоор бууг цэнэглэнэ. "БАЙЛДААНД" дохиогоор сумтай магазиныг буунд угсарч гал хамгаалагчийг зохих тавилт дээр тавиад бууг цэнэглэж буудлагын удирдагчид буудлагад бэлэн болсон тухай илтгэх;
- Бууг байнга бай руу чиглүүлэн буудлагын хавтгайд барих, гар бууны хувьд босоо хавтгайд нь 45 градусаас ихгүй өнцгөөр барихыг зөвшөөрнө;
- Бууг зөвхөн байнд чиглүүлсний дараа гохон дээр хуруу тавихыг зөвшөөрнө. Бусад үед долоовор хурууг гохон дээр тавихыг зөвшөөрөхгүй;
- Цэнэглэсэн бууг хараа хяналтгүй орхихыг хатуу хориглоно. Буу, галт хэрэглэлийг алдаж үрэгдэхээс сэргийлж удирдагчийн хатуу хяналтад байлгах;
- Гал нээх зөвшөөрлийг зөвхөн буудлагын удирдагч улаан дарцаг өргөөд "ГАЛЛА" дохиогоор өгнө;
- Гар буугаар хоёр гараар буудах үед гарын эрхий хуруу замгийн ухрах хэсгийн ард байгаа эсэхийг хянах; /энэ шаардлагыг биелүүлээгүйгээс буудах үед замаг ухрахдаа хурц ирмэгээрээ гарыг гэмтээдэг/
- Буудлагын үед зэвсэг, техникт гацаа гэмтэл тохиолдвол буудагч бие даан гал зогсоож, бууг шалган, эргэж харалгүйгээр буудлагын удирдагчид мэдэгдэх;
- Буудлага хийж байгаа зэвсэг, техникт гацаа, гэмтэл гарсан үед буудлагын удирдагчаас өөр хүн очих, буудлагын талбайд нэвтрэхийг хориглоно;
- Буудагч нь магазин дахь бүх сумыг буудаж дууссан, эсвэл байг бүрэн сөнөөсний дараа буудлагыг зогсоож буудлагын удирдагчид буудлага дууссан тухай илтгэнэ. Бүгд буудаж дуусаад илтгэл өгсний дараа "ГАЛ ЗОГСОО" команд өгч цагаан дарцаг өргөнө;
- Буудлагын удирдагчийн өгсөн "ЗОГС" командаар буудлагыг шууд зогсоож бууг гал хамгаалагч дээр тавина. Буудлагыг зогсоосон шалтгааныг олж зассаны дараа буудлагын удирдагчийн командаар буудлагыг үргэлжлүүлнэ. "СУМ АВ" командаар буудлагыг зогсоож буунаас магазиныг авч цэнэггүй болгох;
- Буудлагын удирдагч буудлагын өмнө болон төгсгөлд буунд заавал үзлэг хийх;
- Буудлага дуусмагц буунд үзлэг хийж, зохих шатны дарга нараар дамжуулан буудлагын удирдагчид илтгэж, зарцуулаагүй үлдсэн галт хэрэглэлийг хураалгана;
- Буудлагын зэвсгийн баарсан сумыг дахин хэрэглэх, оролдохыг хориглоно.
- Буудлагын удирдагч, сум олгогч нар галт хэрэглэлийн тоо хэмжээ, зарлагад байнга хяналт тавих;
- Галт зэвсэгтэй харьцахдаа арчих, цэвэрлэх, задлах, угсрах, буудлага хийх гэх мэт бүхий л ажиллагааны өмнө сумтай эсэхийг заавал шалгана;
- Бохирдсон эсвэл эд анги нь дутуу, бүрэн биш зэвсгийг сургууль дадлагад болон бусад ажиллагаанд хэрэглэхийг хатуу хориглоно;
- Байг үзэх үед галын шугам дээр тавьсан бууг гартаа авч явахыг хориглоно.

3.2. Буудлага үйлдэгч нь дараах тохиолдолд бие дааж, эсвэл буудлагын удирдагчийн командаар галыг нэн даруй зогсооно. Үүнд:

- Буудлагын талбайд хүн, мал, тээврийн хэрэгсэл болон нам өндөрт нисч байгаа нисэх онгоц, нисдэг тэрэг илэрвэл;
- Аюулгүй бүсийн хязгаарын цаана хүн, мал амьтан байрласан, ойрхон зайд тусах, удирдлагын байртай холбоо тасарвал;
- Харуулын пост буудлага хийхэд аюултай болсон тухай дохио өгөх буюу илтгэвэл;
- Буудлагаас болж гал түймэр гарвал;
- Буудагчид шөнийн цагт баримжаа алдвал;
- Буудагчийн биеийн эрүүл мэндийн байдал нь хэвийн бус буюу буудлага үйлдэх боломжгүй болсон тохиолдолд буудагч нь галыг бие даан зогсооно.



## **Дөрөв.Буудлагын дараах арга хэмжээ**

### **4.1. Буудлагын дараа:**

- Бүх бууг цэнэггүй болгосон, гар бууг гэрэнд хийж галын шугамнаас авсан эсэхийг үзлэг хийж шалгах;
- Оролт гаралтын бүртгэлийг бөглөх, галт хэрэглэлийн зарцуулалтын дүн тохирч байгаа эсэхийг шалгах;
- Галт хэрэглэлийн зарцуулалтыг шалгахдаа буудагдсан хонгиог цуглуулах, сумны сери дугаарыг тулгах, зориулалтын газар булах, буудлагын талбайг цэвэрлэх;
- Буудлагын дүн гаргах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

## **Тав. Буудлагын зэвсгийг тирэнд буудаж турших үеийн аюулгүйн арга хэмжээ**

5.1.Буудлагын аюулгүй байдал нь буудлага үйлдэх нарийн зохион байгуулалт, аюулгүйн арга хэмжээ, тогтоосон журмыг чанд сахин биелүүлэх, алба хаагчдын өндөр сахилгаар хангагдана.

5.2.Буудлага үйлдэхийн өмнө буудлагын талбайд үзлэг хийж, буудлага үйлдэгч болон бусад хүмүүсийг галын шугамнаас цааш нэвтрэхийг хориглоно.

5.3.Буудлагын тирэнд төлөвлөгөөнд тусгагдаж засварлагдсан буудлагын зэвсгийг буудаж туршина.


5.4. Буудлага эхлэхийн өмнө дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Тирэнд орох бүх хаалгыг цоожилно, хаалга цонх онгорхой байхад бууг буудаж туршихыг хориглоно;
- Хоёр кабинаас зэрэг буудлага хийх, нэг кабинаас буудлага хийж байхад нөгөө кабины цонхыг онгорхой байлгахыг хориглоно;
- Тирэнд зөвшөөрснөөс бусад хүнийг байлгахыг хориглох;
- Траншей, сумны хүч сааруулагч далан, бай хөдөлгөх хэрэгсэл, буудлагын секторт гадны зүйл, хүн байгаа эсэхийг сайтар шалгах;
- Ажлын болон хэмжилтийн багажуудыг шалган ажлын байрыг бэлтгэх;
- Галт хэрэглэлийг хүлээн авч гэмтэлтэй эсэхийг шалгах;
- Бууны эд анги, механизмуудын ажиллагааг шалгах;
- Буудлага үйлдэхэд бэлтгэх;
- Гэмтэлтэй буугаар буудах, хамгаалах хэрэгсэлгүйгээр буудлага хийхийг хориглох;

5.5. Буудлагын үед дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Кабин дотор турших бууны эд анги болон механизмын харилцан ажиллагааг шалгах;
- Албаны удирдамжийг хатуу баримтлах;
- Гэмтэл илрэх буюу гацаа гарвал буудлагыг шууд зогсоон бууг цэнэггүй болгож, сумыг авч болохгүй байгаа бууг кабинаас гаргана, бууг цэнэглэсэн үед гэмтлийг засахыг хатуу хориглох;
- Сум баарсны дараа 30 секундээс өмнө замаг нээхийг хатуу хориглох;
- Туршсан бууг тусгай тавиурт тавих;
- Кабинаас бууг гаргахын өмнө сумны байр, магазинд сум байгаа эсэхийг шалгах, бууны гал хамгаалагчийг түгжих;
- Тирэн дотор бууг цэнэггүй болгож зориулалтын уут, гэрэнд хийсний дараа авч явахыг зөвшөөрөх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 07... дугаар сарын 07 ны өдрийн 14 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



Зөрчлийн бүртгэл

д/д	Овог нэр	Цэргийн цол	Албан тушаал	Зөрчил	Авсан арга хэмжээ	Гаргасан шийдвэр	Тайлбар

Үйлчилгээ хийгдсэн бүртгэл

д/д	Овог нэр	Цэргийн цол	Албан тушаал	Засвар үйлчилгээ	Чанар байдал	Хүлээн авсан огноо	Хүлээлгэн өгсөн огноо	Тайлбар

Сургалтад ашиглах галт зэвсэг, сум, хэрэгсэл гаргах зөвшөөрөл, олгогдсон бүртгэл

д/д	Огноо	Овог нэр	Албан тушаал, цол	Галт зэвсгийн марк, сөрийн дугаар	Чанар байдал	Зарцуулсан сумны төрөл, тоо хэмжээ	Зөвшөөрөл олгосон хүний овог нэр, цол, албан тушаал, гарын үсэг	Хадгалалтад хүлээн авсан огноо	Тайлбар

Аюулгүй ажиллагааны зааварчилга танилцуулсан бүртгэл

д/д	Овог нэр	Цол	Албан тушаал	Зааварчилгын товч утга	Зааварчилгатай танилцсан огноо гарын үсэг	Тайлбар

Буудлага үйлдсэн бүртгэл

д/д	Овог нэр	Цол	Албан тушаал	Буудлагын зэвсгийн төрөл, сери дугаар	Сумны төрөл	Зарцуулсан тоо	Оноо	Тайлбар